

**НЭР ҮГИЙН –ЛТ ДАГАВАР БОЛОН ҮЙЛ ҮГИЙН –Х БҮХИЙ
ХЭЛБЭРИЙН ХЭРЭГЛЭЭ ХИЙГЭЭД МӨН ЧАНАР**

Ц.Шагдарсүрэн¹

0. Ерөнхий ойлголт

1. Академич Ш. Лувсанвандан монгол өгүүлбэр дэхи нэр,
үйл үгийн харьцааны тухай бичсэн нь
2. Нэг бус тохиолдолд –лт дагавар бүхий үүсмэл нэр үгийн оронд
монгол найруулгазүйн боломжийг ашиглах нь
3. Толь бичиг болон судлагааны бүтээлд монгол хэлний үйл үгийн эс тухайлах
хэлбэрийг хэрхэн тэмдэглэх вэ?
Дүгнэх нь

0. Орчин цагийн монгол бичигийн хэлний найруулгыг үзвэл үйл үгээс нэр үүсхэх –лт дагавар бүхий үгийн хэрэглээ үлэмж их болж, монгол хэлний найруулгазүйн хэмжээг илэрхий эвдэхэд хүрчээ. Үүний учирьг тодловол европ зүгийн хэлнээс монгол болгосон бичигийн орчуулгатай холбоотой бөгөөд сүүлийн үед элдэв сургууль төгөссөн гэх залуучуудын орчуулгад зонхилож байна. Одоохондоо ахмад үеийнхин амьд сэрүүн байгаа тул аман ярианд харьцангуй арай дээр байгаа гэж болох боловч энэ янзаараа засалгүй яваад байх бөгөөд бичиг болон аман хэрэглээнд улам тэлэн “хөгжих” хандалга бас харагдана. Энэ нь нэг талаас төрийн зүгээс эх хэлний эрх хэмжээ (буюу статус)-г дээшлүүлэхийн оронд гадаад хэлийг илүү анхаарсанаас монгол хүний монгол хэлний боловсрол суларсан нь монгол хэлний найруулах ёсоныг анхааран заадаггүй багш нараас үүдэлтэй, нөгөө талаас орчуулах явцад тухайн хоёр хэлний найруулах ёс нь өгүүлбэрзүйн төвшинд адил байдаггүй гэдэг энгийн зүйлийг зааж байгаа багш болон заалгаж байгаа оюутан сурагч нь мэддэггүйтэй давхар давхар холбоотой ажээ.

Монгол өгүүлбэрт хэмжээгээ алдсан –лт дагавар бүхий үгийг мөшхин үзвэл анхны буудал нь орос, англи зэрэг энэдхэг-европ зүгийн хэлнээс орчуулсан орчуулга байх бөгөөд тэдгээр хэлний онцлогоос үүдэж өгүүлбэрийн доторхи нэр үгийн тоо монгол хэлтэй жишихэд харьцангуй олон байдаг бол монгол хэлний онцлогоор тэрхүү олон нэр үгийн нэлээд хэсэг нь үйлт нэрээр буюу нэрэшсэн үйл үг, зарим тохиолдолд үйл үгээр орчуулдаг зүй тогтоолтой, энэ талаар Төрийн шагналт, академич Ш.Лувсанвандан профессор нэг бус удаа тэмдэглэсэн байдаг ч монгол хэлний багш нарын одоогийн байдалаас үзвэл түүнийг уншисан шинж нэгээхэн-бээр үгүй, монгол хэлний олон сурах бичигт энэ мэт бодот хэрэглээ-рүү чиглэсэн зүйл бараг байдаггүй,

¹ ШУ-ы доктор, профессор. МУИС-ийн Монгол хэл, соёлын сургууль.

ерөнхий онолдсон, тэр онолоо монгол хэлний баримттай холбодоггүй нь монгол хэлний найруулгын дурадсан алдаа газар авахад нэмэр болжээ.

Энэ алдаанд ташуур өгсөн бас нэгэн зүйл бол тус улсад 1930-аад оноос гарсан толь бичигт монгол хэлний үйл үгийг толгой үг болгохдоо монгол хэлний үгзүй буюу хэлбэрсудлал (Morphology)-ыг гүйцэд таниагүйн уламаас үйл үгийн -х бүхий хэлбэрийг орос хэлний *неопределённая форма*, англи хэлний *infinitive* хэмээх үйл үгийн эс тухайлах хэлбэр-т шууд оноож, тэр нь яваандаа монгол хэлний янз бүрийн тольд жишиг болж тогтсон учир түүнийг нь багш нь ч тайлбарлаж өгдөггүй тул олон нийт “цэвэр” үйл үг хэмээн итгэж үнэмших болсон явдал. Хэлний шинжлэлд (англиар *infinitive*, оросоор *неопределённая форма* гэдэг) үйл үгийн эс тухайлах хэлбэр нь тухайн үйл үгийн олон хэлбэр үүсэх анхны гараа нь байх ёстой бөгөөд монгол хэлний тухайд тийм хэлбэр нь -х-тэй хэлбэр огт биш, харин бүдүүн тойм төдий хэлэхэд гадна талаасаа *бос-*, *нис-*, *суу-*, *үз(э)-*, *хар(а)-*, *ир(э)-* гэх зэрэг захирах хэлбэртэй дүйдэг номтой. Гэхэдээ гадаад хэлбэр нь адил мэт боловч мөн чанарын хувьд захирах хүсэх хэлбэр нь тухайн үгийн *хэлзүйн хэлбэр*, үйл үгийн эс тухайлах хэлбэр нь тухайн үгийн *хэлзүйн хэлбэр* биш, харин *хэлзүйн бусад хэлбэр* үүсэх анхны гарааны хэлбэртэй дүйх боловч тухайн үйл үгийн үндэс нь бас биш гэдэгийг ялган ойлговол зохино. Энэ бүхэн бол хэлшинжлэлийн хийсвэрлэлтэй холбоотой асуудал. Дээрхи хэдэн жишээнээс харвал *шинэ үсэгийн дүрэм*-ээр үйл үгийн -х-тэй хэлбэр болгоны өмнө эгшиг байна гэж итгэж, мэтгэж байгаа маань чухамдаа монгол хэлний *эгшиг*, *гийгүүлэгч*, *эгшиг-гийгүүлэгч*, *гийгүүлэгч-эгшигийн байр* гэдэг хэлний шинжлэлийн чухаг ойлголтыг бүрмөсөн алдагдуулсан, балархай эгшигийн дүрэм, шилжих эгшигийн гэх зэрэг зохиомол дүрэм бий болсоныг харуулж байгаа хэрэг. Уг нь хэлний шинжлэлд *түргэдэ- түргэдэ-* гэх мэтээр тухайн эгшиг, тухайн гийгүүлэгч, тухайн эгшиг-гийгүүлэгч, тухайн гийгүүлэгч-эгшиг байх ёстой байрандаа байж гэмээ нь үүргээ гүйцэдхэдэг ёстой. Бас математикийн ухаанд нэмэгдэхүүний байр солигдоход нийбэрийн чанар хувирахгүй гэдэг дүрэм байдаг бол хэлний шинжлэлд ийм зүйл байдаггүй. Энэ бүхнээс үүдэж одоо бараг цөмөөрөө *бос-*, *зас-*, *нис-* гэх зэрэг дэвсгэр гийгүүлэгчээр төгөссөн үйл үгийн эс тухайлах хэлбэр нь *босох*, *засах*, *нисэх* гэж буруу ойлгоход хэдийнээ хүрчээ. Үүнээс улбаалж үйл үгийн -х бүхий хэлбэрийг өгүүлбэрзүйн төвшинд нэр болон үйлийн үүрэг гүйцэдхэж цагийн харьцаа илэрхийлдэг үйлт нэр гэж бодохоосоо илүү “цэвэр” үйл үг, үйл үгийн эс тухайлах хэлбэр нь гэж буруу бодож итгэсээр, зарим нь түүнийгээ зүтгэн хамгаалсаар, хэлшинжлэлийн хичээл үзсэнийхээ хэрэгийг хийж чадалгүй олон жилийн нүүрийг үзэв.

1. 1987 онд академич Ш. Лувсанвандан *Нэр томъёоны тухай асуудалд* гэдэг өгүүлэлдээ монгол хэлний найруулахыг европ зүгийн бусад хэлтэй харьцуулбал үйл үгийн хэрэглээ нэр үгийнхээс илүү болохыг онцгойлон тэмдэглээд “**үгэлбэрзүй** (өгүүлбэрзүй^{II, III})-д **үйл үг нь зохион байгуулах төв нь болно**” хэмээн дүгнэжээ. Үүнийг эшлэн толилуулая.

“...Монгол хэл нь үгсийг холбохдоо нэрээр холбохоос үйлээр холбох нь илүү тул нэр томъёо нь ч ялгалгүй дан ганц нэрээр бус үйл үгээр холбогдсон нь олон байна. Ингээж үзвэл нэг нэр томъёо нь нэр, үйлийн аль ч хэлбэрээр байж болохоор тогтоож, найруулах үед аль хэлбэрийг нь хэрэглэхээ шийдвэрлэж байх хэрэгтэй болно. Жишээлбэл: “От живого созерцания к абстрактному мышлению, от него к практике, вст диалектический путь познания действительности” гэсэн орос

үгэлбэр [үүнийг өгүүлбэр гэж хялбарчлан ойлгож болно.¹¹ Ш.] -ийн нэр үгийг нь нэр хэвээр нь махчлан орчуулбал “амьд бясалгалаас хийсвэр сэтгэхүйд, түүнээс практикт, энэ бол бодит байдлыг танилтын диалектик зам мөн” гэсэн монгол үгэлбэр болно. Монгол хэлний үйлээр холбодог хандлагыг анхаарч, нэрийг нь үйл болгож орчуулбал ийм болно: “Бодтой мэдэрч хийсвэрлэн сэтгээд практикт орох нь бодот байдлыг мэдэх диалектик арга мөн” гэсэн үгэлбэр болно. Зарим холбоо үгийн голлосон нэр үгийг үйл үг болгож хэлбэл илүү авсаар хэмнэлттэй болно. Жишээлбэл: ярилцлага хийв – ярилцав, уулзалт хийлээ – уулзлаа гэх мэт болно. Нэг хэлнээс нөгөө хэлэнд орчуулах нь нэг хэлбэрээс нөгөө хэлбэрт орчуулж байгаа хэрэг тул яаж хувилгах нь тухайн хоёр хэлний бүтцээс болно...

...Одоогийн байдлаар нэр үгээр бүтсэн нэр томъёог улам олируулбал бичиг зохиолд нэр үг улам олишрч, үйл үг улам цөөрөх болно. Гэтэл үйл үг нь үгсийн сангийн чухал хэсэг болохоос гадна үгэлбэрзүйд үйл үг нь зохион байгуулах төв нь болно. Үйл үг нь бусад үгсийг биедээ татахын хувьд нэр үгээс илүү болно”²

гээд үүнийгээ жишээгээр тодруулахдаа: *мышление* гэдэг хийсвэр нэр томъёог *сэтгэхүй, сэтгэ-* гэж нэр болон үйл хэлбэрээр тогтоогоод “*мозг – орган мышление*” гэж байвал “*тархи сэтгэдэг эрхтэн*” гэхээс биш “*тархи сэтгэхүйн эрхтэн*” гэхгүй. Харин юмны гарчиг зэрэг зайлашгүй нэр дохио шаардсан нөхцөлд нэгэнт толь бичигт бэлэн орчихсон нэр дохиогоор нь буюу *сэтгэхүй* гэдгээр нь авахад ямар ч бэрхшээл гарахгүй юм... хэмээн тэмдэглэжээ.

Академич энд нэр томъёоны талаар бичсэн өгүүлэлдээ ийнхүү тэмдэглэсэн нь нэр томъёо бол онцгой үүрэг гүйцэдхэхээс биш, онцгой үг огт биш, өгүүлбэрт бусад үгтэй л нэгэн адил ямар нэгэн гишүүн болдог гэдэгийг хэн бүхэн ойлгох тул монгол хэлний найруулгазүйн ерөнхий зарчимаас саланги зүйл огт биш.

Ийм учираас монгол хэлний өгүүлбэр дэхи үйл үгийн хэрэглээ нь орос, англи зэрэг Энэдхэг-европ хэлтэй харьцуулахад нэр үгээс үлэмж илүү бөгөөд зүй нь энэхүү онцлогийг гадаад хэл болон найруулгазүйн хичээл зааж буй багш нар давын өмнө тайлбарлаж, орчуулгын дадалга хийлгэхдээ баримтаар нутлаж, монгол болон орос, англи зэрэг хэлний найруулах ёсны ялгааг ой тойнд нь оруулбал зохилтой. Ингэж гэмээ нь багшийн заасан хичээлийн үр дүн дээшилэж, оюутан сурагчийн сурсан мэдэлгэ гүнзгийрч тэр чинээгээр тэдний орчуулгын ур чадвар сайжирах нэгэн учир бүрдэх болно.

Нэгэнт ийм болохоор орос, англи зэрэг гадаад хэлнээс монгол болгох, монголоос гадагш нь орчуулах зэрэгт анхаарвал зохих нэгэн зүйл бол аль нэг хэлэнд нь нэр үг байж гэмээ нь нөгөөд нь заавал нэр үгээр, үйл үг байж гэмээ нь заавал үйл үгээр орчуулна гэдэг зарчим байж болохгүй бөгөөд хэл хэлний найруулах ёсонд нь тохируулж гэмээ нь таны орчуулга найруулгазүйн хувьд төгөс сайн болох ажээ.

2. Монгол хэлний өгүүлбэрзүй болон найруулах ёсны нэгэн өвөрмөц онцлог нь академич Ш. Лувсанванданы тодорхойлсончилон үйл үг нь “*өгүүлбэрийг зохион байгуулах төв нь болж өгдөг*” явдал бөгөөд үүнд: үйл үг, үйлэшсэн нэр буюу үйлт нэр

² Ш. Лувсанвандан, *Нэр томъёоны тухай асуудал*, - *Studia Mongolica*, Том. XIII (21), Улаанбаатар, 1987, 6-7-р тал; Ш. Лувсанвандан, *Хэл, харьцаа, тэмдэг*, Улаанбаатар, 2005, 240-241-р тал.

нь цагийн харьцааг нэгэн дор уян хатан гаргаж өгдөг онцгой чадвартай. Одоо манайхины хэрэглэж буй “цөлжилт” гэдэг үгээр жишээ авахад энэ үг нь ерөнхий ойлголт өгөхөөс биш, цагийн нарийн харьцаа илэрхийлдэггүй. Гэтэл уг ухагдахуун цагийн харьцааг гаргах тохиолдолд мөнөөхи “цөлжилт” гэдэг үүсмэл нэр үгийг хэрэглэсэн тохиолдолд, өнгөрсөн цагийн тухайд “цөлжилт болжээ”, *цөлжилт явагдсан байна*. эсбөгөөс ирээдүй цагийн тухайд “цөлжилт болно”, “цөлжилт явагдана” гэх мэтээр сунжирсан нуршуу, тэгээд дээр нь монголжуу бус найруулга хэрэглэхээс өөр аргагүйд хүрнэ. Гэтэл монгол хэлнээ ийм санааг өнгөрсөн цагийн тухайд “цөлжижээ”, “цөлжисон (байна)”, ирээдүй цагийн тухайд “цөлжинө” гээд цагийн харьцаатай нь бараг ганц үгээр уг ухагдахууныг товч бөгөөд төгөс илэрхийлэх бүрэн боломжтой билээ. Тэгэхдээ оносон, зохисон шаардалгатай газарт нь, тухайлбал: өгүүлэлийн нэр усанд ч юм уу “цөлжилт” гэдэг үгийг хэрэглэж болохгүй гэсэн үг огт биш. –*лт* дагавар бүхий үүсмэл нэрийг зохихгүй газар хэрэглээд байх нь өгүүлбэрийг сунжруулахын хажуугаар монгол хэлний өгүүлбэрийн найруулгыг нэр үг зонхилог харь хэлний махан орчуулга мэт болгодог байна. Нэг жишээ авая: Монгол хэлний найруулгаар *татвараас хөнгөлөх* гэдэг санааг одоо их төлөв *татварын хөнгөлөлт* гэх болсон нь мэргэжилийн бус хүний хувьд үгийн сангийн боломжийн нэгэж мэт санагдаж болох ч харилцахын гол нөхцөлийг бүрдүүлж өгдөг өгүүлбэрт орохдоо нуршуу болохоод зогсохгүй монгол хэлний өгүүлбэрзүйн найруулгын онцлогийг алдагдуулахад хүрдэг. Монголоор ... *татвараас хөнгөлжээ* гээд тухайн санааг хоёрхон үгээр илэрхийлэх боломжтой. Тэгэвэл *татварын хөнгөлөлт* гэдэг үгийг өгүүлбэрт оруулахад ...*татварын хөнгөлөлт үзүүлжээ* гэж гурван үгээр уул санааг гаргахад хүрнэ. Бусад бүх зүйлд баримтладаг мөнгө зардалтай холбоотой цаг, зай, ажил, цаас ... хэмнэх зарчим хэлэнд ч, бичигт ч нэгэн адил хүртээлтэй.

3. Толь бичиг болон монгол хэлний үйл үгийн тухай бүтээлд монгол хэлний үйл үгийн эс тухайлах хэлбэрийг хэлшинжлэлийн үндэстэй хэрхин зөв тэмдэглэвэл зохих вэ? гэдэг асуулт гарах ёстой байсаар удсан боловч толь зохиогчид түрүү үеийн буруу “хэвшил”-ийг дагасаар, нэрт монголч эрдэмтэдийн толь болон судлагааны бүтээлд үйл үгийн тухайн хэлбэрийг хэрхин тэмдэглэсэн зарчимын цаад учир холбодолыг анхааралгүй өнөөдөрийг хүргэжээ.

Г. И. Рамстедт (G. J. Ramstedt), А. Мостаерт (A. Mostaert), Н. Поппе (N. Poppe) зэрэг томоохон монголч эрдэмтэдийн зохиосон монгол толгойтой болон орчуулгын толь бичигтээ, мөн монгол хэлний судлалын ном бүтээлдээ монгол үйл үгийн эс тухайлах хэлбэрийг ямагт –х-гүй буюу гаднаас нь харвал тухайн үйл үгийн захирах хэлбэртэй дүйх байдлаар тэмдэглэсэн байдаг. Тэд бол цөм мэргэжисэн, тухайлбал Г. И. Рамстедт, Н. Поппе нар бол ерөнхий хэлшинжлэл хийгээд Алтай хэлшинжлэлийн салбарт дэлхийн дансанд орсон нэртэй эрдэмтэд тул тэднийг монгол хүн биш тул андуурсан, бид монгол хэлээ “мэддэг” монгол хүн учир монгол хэлний судлагдахуунаа андуураагүй гэж үзэхийн аргагүй. Чухамдаа гадаадын нэг бус монголч эрдэмтэн, судлаач нар хөгшин залуу гэлтгүй монгол хэлний мөн чанарыг одоогийн монголчуудаас ч илүү сайн мэдэж, бичиж, найруулж байгаа билээ. Бид “монгол хүн юм чинь монгол хэлээ мэдэлгүй яадаг юм” гэж хоосон аархадаг хэрнээ гадаад хэлийг дээдлэж, эх хэлээ доодлосоор үнэндээ “мэдэхгүй” болчихоод байгаа нь соносоход эгдүүтэй мэт санагдавч хэдийнээ гарцаагүй үнэн болчихжээ. Миний мэдэхээр монгол хүн бичсэн зүйлийнхээ найруулга, алдаа мадагийг нь хамт ажилладаг гадаадын хүнээр засуулдаг явдал бидний дунд хэдийнээ буй болжээ.

Монгол хэлний уламжлалт толь бичигийн зүйл, хоёр, гурав, таван хэлний орчуулгын толь бичигт үйл үгийг *явав, явлаа, явсан, явжээ* ... гэх мэтээр гол төлөв хэлзүйн хэлбэрээр оруулдаг нь бараг тухайн цагтаа тогтсон журам болсон байжээ. Орчин үед буюу европ зүгийн тользүйн уламжлалд ийм журам байдаггүй бөгөөд үйл үгийг, ялангуяа толгой үг болгоход (англиар *infinitive*, оросоор *неопределённая форма* гэдэг) эс тухайлах хэлбэрээр нь оруулдаг бөлгөө. Аль ч хэлний үйл үгийн тухай ном зохиол, илэдхэл ярианд, тухайн үйл үгийн цохож авсан хэлбэрийг л онцлож яриагүй бол тухайлбал: англи хэлний *to be*, франц хэлний *être*, орос хэлний *быть* гэх зэргээр эс тухайлах хэлбэрийг нь хэрэглэдэг билээ. Гадаад хэлний багш нар цаад хэлээ (нэгэнт сурах бичиг, ном зохиолд нь тийм байдаг болохоор) тийнхүү зөв заадаг аталаа монгол хэлний дүйх үйл үгийг заавал –х-тэй хэлбэрээр оноон орчуулдаг нь нэг талаас монгол хэлний толь, судлагааны бүтээлийг дагасан хэрэг гэж “цагаадхаж” болох ч, нөгөө талаас нь хэлшинжлэл, монгол хэлний хичээл дээр монгол хэлний үйл үгийн эс тухайлах хэлбэр нь гадна талаасаа захирах хүсэх хэлбэртэй таардаг гэж үзсэн зүйлээ хэрэглэхгүй байгааг яв ч зөв гэхийн аргагүй.

Иймэд олон нийтийн буруу ойлголтыг залруулахад давын өмнө толь бичигт монгол хэлний үйл үгийг эс тухайлах хэлбэрээр нь оруулах, хэлний багш нар монгол хэлний үйл үгийг тухай хичээл заахдаа “*явах*” гэдэг үйл үг гэлгүй “*яв-*” гэдэг үйл үг гэж тодлон заах цаг хэдийнээ болжээ (энэ нь үйл үгийн –х-тэй хэлбэрийн тухай заахад хамаарахгүй гэдэг нь хэн бүхэнд тодорхой юм).

Толь бичигт монгол үйл үгийн эс тухайлах хэлбэрийг яваандаа зөвөөр нь оруулах шаардалгатай боловч эхний шатанд олоноо зуршил болсон –х-тэй хэлбэрийг нь байлгаж дотор нь үйл үгийн эс тухайлах хэлбэрийг араар нь зааглан зурж, ялган тэмдэглэхэд болохгүй гэх газаргүйн дээр ингэж тэмдэглэж гэмээ нь үйл үгийн “–х-ийн өмнө *ямагт эгшигтэй байна, тэр эгшигийг шилжүүлэхгүй*” гэдэг дүрэмийн “мөн чанар”-ыг бодтой бөгөөд нэгэн дор шууд харьцуулж харах боломжийг олгоно. Тухайлбал: толь бичигт толгой үг болгохдоо ав/ах, багас/ах, бос/ох, гар/ах, нис/эх, өг/өх; ай/х, буу/х, гайха/х, идэх/х, чада/х, ява/х гэх мэтээр үйл үгийн эс тухайлах хэлбэрийн араар нь зурж тусхаарласан тохиолдолд, тухайн үйл үгийн үндэс (монгол хэлний үйл үгийн эс тухайлах хэлбэр, тухайн үйл үгийн үндэстэй хэлбэрийн хувьд тохирох боловч мөн чанарын хувьд хоёр өөр зүйл гэдэгийг дээр өгүүлсэн билээ) нь:

- Тухайн үйл үгийн үндэс чухамдаа эгшигээр төгссөн үү? гийгүүлэгчээр төгссөн үү? (Энэ ялгаа кирилл үсэгт шилжисэний дараа хэдэн үеийн туршид монгол хүний аманд нь хадгалаастай: *авч, өгч* гэх мэтээр –ч дагавар залгаж байвал дэвсгэр, *явж, идэж* гэх мэтээр –ж дагавар залгаж байвал эгшигтэй хэмээн ялган чадаж байсан боловч цаг өнгөрөх тусам аманд нь байсан тэр дархлаа алга болж одоогийн хүмүүс дээрхи мэтээр салган ойлгохоо болих тийшээ хандаж *гарч* гэх ёстой үгийг *ор(о)ж* гэдэгийн “хуурамч” жишигээр *гарж* гэж хэлэх бичихэд хүрчээ.);
- хэрэвзээ гийгүүлэгчээр төгссөн бол *авах, өгөх* гэх мэтээр байх ёсгүй эгшигийг бид яагаад тэмдэглэж байгаа юм?
- монгол хэлний авиазүйн хуулиар –х гийгүүлэгч дэвсгэрлэдэггүй байтал бид яагаад дэвсгэрлүүлэн тэмдэглэж үеийн бүтэцийг эвдэж байгаа юм бэ? (тэгээд ч *харахад, үзэхэд, идэхэд* гэх мэтээр үйл үгийн –х-ээр төгссөн үгийн ард –т биш, –д дагавар залгаж завсар нь зохих эгшигийг “нэмэн” бичиж байгаа нь

угтаа тухайн –х нь дэвсгэр биш, ардаа зохих зохих эгшигтэй байсаныг давхар батлаж байгаа хэрэг төдийгүй одоо “нэмэн” жийрэглэж байгаа мэт ойлгогдох болсон эгшиг нь угтаа байсан хэрэг.);

- энэ бүхнээс үүдэн манайхитай адилхан кириллжин бичигтэй монгол хэлтэн буриадууд үйл үгийн үндэсийг байх ёстой байдалаар нь буюу *абхуулха* (авахуул/ах), *гаргаха* (гарга/х), *үгүүлэх* ([юм] өгүүл/эх), *үзэх* (үзэ/х), *хараха* (хара/х), *ябаха* (ява/х) гэх мэтээр тухайн үгийн үндэсэнд эгшиг байх газар эгшигтэй нь, эгшиггүй газар нь дэвсгэр гийгүүлэгчээр ялган бичдэг³;
- буриад нөхөдүүд толь бичигтээ үйл үгийг –х-тэй оруулдаг боловч тэрхүү –х нь ардаа ямагт эгшигтэй байдагийн учир шалтгаан юу вэ?
- бидний зөв хэмээн бодож буй “... үйл үгийн –х ямагт өмнөө эгшигтэй байна, үйл үгийн –х-ийн өмнөхи эгшигийг гээхгүй...” гэж бүх үйл үгийг социализмын “тэгшидхэх” зарчимаар дүрэмжүүлсэн нь монгол хэлний мөн чанартай тохирох эсэх? (Олон хэлний тойм байдалыг үзэхэд угаасаа цаад зүйл нь харилцан адилгүй, жишээ нь англи хэлнээ “*дүрэм бус (irregular) үйл үг*” гэж бусадтайгаа адилгүй хувирдаг баахан үйл үг байдаг, франц хэлний үйл үгийн хувилалыг дотор нь гурав ангиладаг гэх зэрэг ялгаа байдагтай нэгэн адил монгол хэлний бүх үйл үгийг “тэгшидхэн” дүрэмжүүлэх үндэс боломж цаанаа байхгүй.);
- зөвхөн энэ тохиолдолд, түүхэн хэлшинжлэлийн хүрээнд, монгол бичигт үйл үгийн дэвсгэр гийгүүлэгчээр төгөссөн үндэсийн араас гийгүүлэгчээр эхлэсэн зарим дагавар болон нөхцөл залгахад *abugad*, *yabugulugad* гэх мэтээр ихэнхидээ гэдэс, зарим нэг тохиолдолд шүд нэмэн жийрэглэдэгийн цаад учир шалтгаан тодорч, тухайн юмыг үндэс углуургаар нь ойлгох;
- Монгол хүний нэрийн санд *Баясах, Дэлгэрэх, Мандах, Орших, Өрнөх* гэх зэрэг –х бүхий “үйл” үг олон байдаг нь нэрийн үүргээр орж буй хэрэг бөгөөд энэ нь тухайн үйл үгийн эс тухайлах хэлбэр биш болохыг, бас бидний ойлгодог шиг “цэвэр” үйл үг биш болохыг давхар харуулж байна.

Энэ мэтээр олон зүйлийн учир шалтгаан хийгээд хор холбогдол нь хэвийн хөгжилтэй хэн бүхэнд аяндаа тодорхой, тогтолцоотой ойлгогдох болно.

Дүгнэж хэлэхэд: дээр өгүүлсэнчилэн, монгол хэлний үйл үгийн эс тухайлах хэлбэрийг толь бичигт зөв оруулахын хажуугаар монгол хэлний –х бүхий үйлт нэрийн мөн чанар, -лт дагавар бүхий үүсмэл нэр үг гэнэт олширсоны учир холбогдол хийгээд монгол хэлний өгүүлбэрийг орос англи зэрэг бусад хэлтэй харьцуулахад үйл үг, үйлэшсэн нэрийн үүрэг үлэмж их байдаг талаар монгол болон гадаад хэлний багш нар өгүүлбэрзүй, орчуулга, орчуулгын дадалга, найруулгазүйн хичээлдээ хэлшинжлэлийн үндэстэй тайлбарлаж баймааж нь нэгэн үеийн ташааралын уг сурвалж нь монгол хэлний авиазүйн онцлогийг огт харгалзаагүй юм байна гэж нийтээр зөв ойлгох замыг нь засахын хажуугаар, монгол хэлний зүй тогтолыг гайхалтай тусхасан монгол бичигээ аваагүй тохиолдолд оросжин кирилл бичиг байсан ч, латин бичиг хэрэглэсэн ч зөв бичихзүйг дахин сайжруулан боловсруулах шаардалгатайг улам бүр мэдрүүлэх болно. Тэр чинээгээр олон нийтийн эх хэлний боловсрол ч дээшилэх болно. Аливаа үндэстэний эх хэл гэдэг бол хаана ч гэсэн шинжлэх ухааны үндэслэл нь

³ *Буриад-орос словарь / Бурятско-русский словарь*, Составил К. М. Чермисов, Москва, 1973, стр. 25а, 149б, 498а, 552б.

бүх талаараа олон нийтэд ойлгомжтой, хүртээлтэй байдаг бөгөөд үүгээрээ нэгэн хэсэгтээ нууц байдаг улс төрийнхний тоглоомоос ялгардаг. Аливаа хэлний асуудал бол зор эзэрхийлсэн нийгэмийн “нэртэй төртэй” гэгдэж явсан хэн нэгэн хүн, дарга даамалын нэрээр түрий барих зүйл огт биш.

Ямар ч шинжлэх ухааны салбар нь нийгэмийн цаашидын аж төрөлд судлагааныхаа үр дүнг хэрэглэх гэж цаг зав, хөрөнгө хүч зарцуулдаг байтал монгол хэлний талаархи эрдэм шинжилгээний ажилын батлагдсан үр дүнг түрүүчийн нийгэмээс улбаалж, одоо ч гэсэн улс төрийн нуугдамал учир шалтгааны уламаас энэ мэтээр амьдрал ахуйд огт хэрэгсэхгүй, хэрэглэхгүй байгаа нь монгол хэлийг судлах нийгэмийн хэрэгцээ байна уу? үгүй юү? гэдэг асуулт тавихад эрхгүй хүргэж байна.

SUMMARY

In this paper the author has taken two aspects of the contemporary Mongolian language and drew the following conclusions.

1. The usage of noun with suffix *-nm* is very common in the contemporary Mongolian language on account of direct copy of sentence structure from Russian and English languages so on. This caused obvious deficiency in the Mongolian stylistics.
2. Today, gerund *-x* of the Mongolian verb has not fully and correctly explained in the sphere of teaching, so great mass of the population think wrongly that it is « true » verb and entry form in dictionaries. It is the cause to misunderstand the syllable and word structure.

The author considered that these mistakes need to be corrected when compiling dictionary, translating, composing and teaching Mongolian. If corrected, this would help to keep the ecology of the Mongolian language pure and the social status in the Mongolian language will be increased.